



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2023 .02.17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
“Глобаль капитал аудит” ХХК-ын захирал Д.Энхтуяа
Утас: 89499922 Цахим хаяг: enkhtuyad@gmail.com
Аудитор Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5.Аудитын илрүүлэлт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.14 № 2/34

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотой "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам өөрчлөн батлах тухай" ЭМДҮЗ-ийн 2022.03.23-ны 05 тоот тогтоол гарч, Эрүүл мэндийн байгууллагууд нэг иргэнээр тооцсон нормативт зардлаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна.

Үйл ажиллагааны орчинд бүтцийн өөрчлөлт гараагүй, дээрхи тогтоолын дагуу Эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон зардлыг ЭМД-ын сангаас өвчний оношийн төрлөөр, насны ангилалаар тогтоосон тарифт үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

005020202

D/2023-A4 Alban toot doc

Дээрхи өөрчлөлттэй холбоотойгоор Эрүүл мэндийн байгууллагууд 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран улсын төсвийн , орон нутгийн төсвийн гэж тайлагнан Сангийн яамны e-balance.mof.gov.mn системд шивж оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>401,126,892.99</u>	<u>332,721,718.04</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	225,173,169.75
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	225,173,169.75
3121	Төгрөг	00.00	225,173,169.75
31211	Төрийн сангийн харилцах	00.00	225,173,169.75
33	АВЛАГА	327,086,000.00	4,044,874.04
33300	Татаас, санхүүжилтийн авлага	327,086,000.00	00.00
335	Бусад авлага	00.00	4,044,874.04
3351	Байгууллагаас авах авлага	00.00	4,044,874.04
34	УРЬДЧИЛГАА	200,000.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	200,000.00	00.00
34713	Цалингийн урьдчилгаа	200,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	73,840,892.99	103,503,674.25
351	Түүхий эд материал	38,408,595.00	65,066,670.23
35130	Эм боох материал	38,408,595.00	65,066,670.23
354	Хангамжийн материал	35,432,297.99	38,437,004.02
35410	Бичиг хэргийн материал	831,000.00	2,859,050.00
35440	Түлш, шатах тослох материал	629,650.00	00.00
35450	Барилгын засварын материал	2,600,000.00	00.00
35460	Хүнсний материал	4,705,810.00	2,725,750.00
35470	Бусад хангамжийн материал	26,665,837.99	32,852,204.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,718,500,006.37</u>	<u>1,753,481,986.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,718,500,006.37	1,753,481,986.49
392	Биет хөрөнгө	1,692,905,756.41	1,727,956,486.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,739,069,245.55	1,739,069,245.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-181,322,440.59	-240,006,621.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,150,000.00	46,580,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,187,500.00	-29,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	269,810,198.61	329,256,926.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-167,287,788.46	-201,549,215.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,182,393.50	144,658,843.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-48,966,352.20	-60,610,692.15
39217	Ном	458,000.00	458,000.00
393	Биет бус хөрөнгө	25,594,249.96	25,525,499.92
39303	Бусад биет бус хөрөнгө	26,113,000.00	26,113,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-518,750.04	-587,500.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,119,626,899.36</u>	<u>2,086,203,704.53</u>

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,493,545.94	7,406.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,493,545.94	7,406.00
413	Өглөг	8,493,545.94	7,406.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,091,976.34	7,406.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,401,569.60	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,111,133,350.42	2,086,196,295.53
51	Засгийн газрын хувь оролцоо	2,111,133,350.42	2,086,196,295.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	403,539,875.00	403,539,875.00
51101	Өмч: - төрийн	403,539,875.00	403,539,875.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,680,820,648.16	1,655,883,593.27
51210	Өмнөх үеийн үр дүн	1,680,820,648.16	1,680,820,648.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-24,937,054.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,772,827.26	26,772,827.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,119,626,896.36	2,086,203,701.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,278,760,218.22	958,876,025.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,420,796.22	211,943,515.81
120	Нийтлэг татварын бус орлого	95,420,796.22	211,943,515.81
120017	Үнэ төлбөргүй орлого ҮХ	71,826,451.01	33,804,028.00
120018	Үнэ төлбөргүй орлого БМ	23,514,645.21	25,416,087.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,700.00	152,723,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,700.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	152,723,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,183,339,422.00	746,932,510.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	480,577,200.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	480,577,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	611,871,128.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,676,128.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	327,086,000.00	00.00
131107	ЭМД-ын орлого	231,109,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	74,388,854.00	81,298,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,388,854.00	81,298,400.00

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,502,240.00	665,634,110.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,502,240.00	665,634,110.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	920,603,120.80	983,813,080.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	920,603,120.80	983,813,080.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	847,623,299.88	982,684,585.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	358,004,749.94	397,133,293.00
210101	Үндсэн цалин	358,004,749.94	397,133,293.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,921,233.81	51,418,713.31
210201	Тэтгэврийн даатгал	34,472,482.47	36,155,844.16
210202	Тэтгэмжийн даатгал	3,828,436.00	3,815,516.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,054,107.00	3,052,673.21
210204	Ажилгүйдлийн даатгал	714,566.00	762,843.32
210205	Эрүүл мэндийн даатгал	6,851,642.34	7,631,836.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,278,854.00	80,489,513.42
210301	Гэрэл, цахилгаан	3,736,066.00	4,741,043.42
210302	Түлш, халаалт	69,142,788.00	74,748,870.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	999,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,832,129.80	41,107,886.00
210401	Бичиг хэрэг	3,245,000.00	4,096,450.00
210402	Тээвэр, шатахуун	28,406,129.80	34,666,036.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,001,000.00	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	125,400.00
2105	Нормативт зардал	148,288,892.80	192,706,617.77
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	118,544,702.80	166,494,957.77
210502	Хоол, хүнс	29,744,190.00	26,211,660.00
2107	Томилолт, зочны зардал	758,000.00	2,834,000.00
210702	Дотоод албан томилолт	758,000.00	2,834,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,267,249.00	25,173,658.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,817,249.00	23,804,798.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	1,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	68,860.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,272,190.53	191,820,903.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,742,645.50	83,449,705.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,529,545.03	108,371,197.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,979,820.92	1,128,495.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,276,127.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,000,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,276,127.00	00.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,128,495.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1128495.54
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,703,693.92	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,696,997.92	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	358,157,097.42	-24,937,054.89
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	358,157,097.42	-24,937,054.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	856,333,122.00	1,226,741,910.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,700.00	152,723,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	79,700.00	152,723,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,700.00	152,723,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,700.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	152,723,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	856,253,422.00	1,074,018,510.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	480,577,200.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	480,577,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	284,785,128.00	288,812,645.94
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,676,128.00	288,812,645.94
131107	ЭРүүл мэндийн даатгалын орлого	231,109,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	74,388,854.00	81,298,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,388,854.00	81,298,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,502,240.00	703,907,464.06
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,502,240.00	703,907,464.06
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	856,333,122.00	892,019,590.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	856,333,122.00	892,019,590.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,353,301.08	890,891,094.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	360,429,355.94	400,171,919.00
210101	Үндсэн цалин	232,510,535.40	237,053,437.00
210102	Нэмэгдэл	101,899,085.74	99,395,936.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,747,649.80	8,292,000.00
210104	Урамшуулал	20,272,085.00	55,430,546.00

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,763,802.14	47,617,522.31
210201	Тэтгэврийн даатгал	30,007,754.14	32,354,656.15
210202	Тэтгэмжийн даатгал	3,682,381.00	3,815,516.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,930,353.00	3,052,673.21
210204	Ажилгүйдлийн даатгал	737,755.00	762,843.32
210205	Эрүүл мэндийн даатгал	7,405,559.00	7,631,833.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,888,854.00	80,131,496.46
210301	Гэрэл, цахилгаан	4,346,066.00	4,383,026.46
210302	Түлш, халаалт	69,142,788.00	74,748,870.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	999,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,250,499.80	41,257,801.00
210401	Бичиг хэрэг	1,184,300.00	2,786,400.00
210402	Тээвэр, шатахуун	24,208,399.80	28,153,701.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,001,000.00	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,918,100.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	938,700.00	8,097,700.00
2105	Нормативт зардал	29,873,159.20	91,236,708.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,048,459.20	72,012,108.00
210502	Хоол, хүнс	5,824,700.00	15,042,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	4,182,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	658,000.00	2,834,000.00
210702	Дотоод албан томилолт	658,000.00	2,834,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,032,005.00	204,342,372.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	231,582,005.00	202,768,637.94
210802	Аудит, баталгаажуулалт,	450,000.00	1,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	233,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	38,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	1,735.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,457,625.00	20,799,275.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,457,625.00	20,799,275.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,979,820.92	1,128,495.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,276,127.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,000,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,276,127.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,128,495.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,128,495.54

Буцаагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,703,693.92	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,696,997.92	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	334,722,319.75
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	109,549,150.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	109,549,150.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	109,549,150.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	109,549,150.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-109,549,150.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	225,173,169.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	225,173,169.75

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,322,663,553.74	1,752,976,256.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,322,663,553.74	1,752,976,256.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	358,157,097.42	358,157,097.42
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,680,820,648.16	2,111,133,350.42
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,680,820,648.16	2,111,133,350.42
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,680,820,648.16	2,111,133,350.42
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-24,937,054.89	-24,937,054.89
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,655,883,593.27	2,086,196,295.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	828,397,300.00	675,160,498.77	153,236,801.23	81.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	828,397,300.00	675,160,498.77	153,236,801.23	81.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	828,397,300.00	675,160,498.77	153,236,801.23	81.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,009,500.00	370,276,429.00	10,733,071.00	97.18
210101	Үндсэн цалин	233,497,000.00	237,585,537.00	-4,088,537.00	101.75
210102	Нэмэгдэл	101,399,200.00	81,346,384.00	20,052,816.00	80.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,930,000.00	6,264,000.00	666,000.00	90.39
210104	Урамшуулал	39,183,300.00	45,080,508.00	-5,897,208.00	115.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,626,200.00	47,617,522.31	8,677.69	99.98
210201	Тэтгэврийн даатгал	32,385,800.00	32,354,656.15	31,143.85	99.90
210202	Тэтгэмжийн даатгал	3,810,100.00	3,815,516.56	-5,416.56	100.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,048,100.00	3,052,673.21	-4,573.21	100.15
210204	Ажилгүйдлийн даатгал	762,000.00	762,843.32	-843.32	100.11
210205	Эрүүл мэндийн даатгал	7,620,200.00	7,631,833.07	-11,633.07	100.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,260,000.00	80,131,496.46	1,128,503.54	98.61
210301	Гэрэл, цахилгаан	5,511,000.00	4,383,026.46	1,127,973.54	79.53
210302	Түлш, халаалт	74,749,000.00	74,748,870.00	130.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	999,600.00	400.00	99.96
2104	Хангамж, бараа материалын зардал	67,713,200.00	33,859,857.00	33,853,343.00	50.00
210401	Бичиг хэрэг	7,504,800.00	2,006,000.00	5,498,800.00	26.73
210402	Тээвэр, шатахуун	38,508,400.00	26,582,697.00	11,925,703.00	69.03
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	1,980,000.00	220,000.00	90.00
210404	Ном, хэвлэл	700,000.00	0	700,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	240,000.00	3,260,000.00	6.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,300,000.00	3,051,160.00	12,248,840.00	19.94
2105	Нормативт зардал	112,486,300.00	91,419,408.00	21,066,892.00	81.27
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	86,940,200.00	72,012,108.00	14,928,092.00	82.83
210502	Хоол, хүнс	17,536,100.00	15,224,800.00	2,311,300.00	86.82
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,010,000.00	4,182,500.00	3,827,500.00	52.22
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	3,357,000.00	2,834,000.00	523,000.00	84.42
210702	Дотоод албан томилолт	3,357,000.00	2,834,000.00	523,000.00	84.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,902,800.00	14,988,877.00	6,913,923.00	68.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,450,000.00	13,415,142.00	5,034,858.00	72.71
210802	Аудит, баталгаажуулалт	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	233,600.00	233,600.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,400.00	38,400.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,400.00	1,735.00	8,665.00	16.68
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,870,400.00	0	1,870,400.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,042,300.00	31,032,909.00	79,009,391.00	28.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,042,300.00	31,032,909.00	79,009,391.00	28.20
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	828,397,300.00	900,333,668.52	-71,936,368.52	108.68
320001	Орон нутгийн төсвөөс	81,298,400.00	80,169,904.46	1,128,495.54	98.61
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	594,375,500.00	629,167,010.00	-34,791,510.00	105.85
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	594,375,500.00	629,167,010.00	-34,791,510.00	105.85
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	152,723,400.00	190,996,754.06	-38,273,354.06	125.06
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	152,723,400.00	190,996,754.06	-38,273,354.06	125.06
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30	30	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	10	10	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30	30	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19	19	0.00	100.00

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	0.00	100.00
--------	--	----	----	------	--------

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар “Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх” гэж зорилго зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар :

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудад нийцүүлэн гарсан тогтоол, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Харин тайлант онд "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга , журам өөрчлөн батлах тухай " ЭМДҮЗ-ийн 2022.03.23-ны 05 тоот тогтоол гарч , эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн журамд өөрчлөлт орж нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож эхэлсэн ба тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайлан ЭМЯ-нд нэгтгэгдэж, орон нутгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, Сангийн яамны Э-тайланд хөрөнгө шилжүүлэн тайланг гаргаж, орон нутгийн тайлан эхний үлдэгдэлтэй эцсийн үлдэгдэлгүй, Улсын төсвийн тайланд эцсийн үлдэгдлээр тайланг нэгтгэсэн байна.

Дотоод хяналтыг ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,086,136.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 33,423.2 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Мянган төгрөгөөр
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	401,126.9	332,721.7	(68,405.2)
Мөнгөн хөрөнгө	-	225,173.2	225,173.2
Авлага	327,086.0	4,044.9	(323,041.1)
Урьдчилгаа	200.0	-	(200.0)
Бараа материал	73,840.9	103,503.7	29,662.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,718,500.0	1,753,482.0	34,982.0
Үндсэн хөрөнгө	2,142,782.8	2,286,136.0	143,353.2
Хуримтлагдсан элэгдэл	(424,282.8)	(532,654.0)	(108,371.2)
Нийт хөрөнгө	2,119,626.9	2,086,203.7	(33,423.2)
Өр төлбөр	8,493.5	7.4	(8,486.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,111,133.4	2,086,196.3	(24,937.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,119,626.9	2,086,203.7	(33,423.2)

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 225,173.2 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын санхүү даатгалын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны өөрчлөлт нь өмнөх оны ЭМД-ын сангаас авах авлагын үлдэгдэл 327,086.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, тайлант хугацаанд аймгийн ЭМГ-аас 1,399.6 мянган, “Дэлгэрэх тун” ХХК-иас 2,489.1 мянган төгрөгийн

эмийн авлага , Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-иас гэрэл цахилгааны 156.7 мянган төгрөгийн авлага тус тус шинээр үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 103,503.7 мянган төгрөг болж 29,662.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд нийт 312,391.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн ЭМГ болон ЭМГ-аар дамжуулан ЭМЯ бусад байгууллагаас 25,416.1 мянган төгрөгийн бараа, материалыг шилжүүлэн авч, 308,144.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,286,136.0 мянган төгрөг болж 143,353.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 109,549.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн ЭМГ-аас 12,314.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч , хандиваар 21,490.0 мянган төгрөгийн хөрөнгийг авсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,086,196.3 мянган төгрөг болж 24,937.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд ЭМД-ийн сангаас санхүүжих нэг иргэнээр тооцсон зардлыг 659,398.0 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 139,326.8 мянган төгрөгөөр бууруулан 520,071.2 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой 8 удаа төсөвт өөрчлөлт оруулжээ

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас 594,375.5 мянган , дээд шатны төсөв захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилан олгох буюу туслах үйл ажиллагааны орлогоос 152,723.4 мянган, орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлын санхүүжилтэд 81,298.4 мянган , нийт зарлага санхүүжилтийг 828,397.3 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 629,167.0 мянган, туслах үйл ажиллагааны орлогоос 152,723.4 мянган , орон нутгийн төсвөөс 81,298.4 мянган , нийт 900,333.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 675,160.5 мянган төгрөг буюу 81.5 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 1,128.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, ЭМД-ийн сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан 34,791.5 мянган төгрөгөөр илүү авсан, туслах үйл ажиллагааны орлогоос 152,723.4 мянган төгрөгөөр санхүүжиж, олгосон санхүүжилтээс 225,173.2 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	828,397.3	675,160.5	153,236.8	81.5
АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	81,298.4	80,169.9	1,128.4	98.6
АРГА ХЭМЖЭЭ 80302-Нэг иргэнд ногдох нормативт зардал	376,726.5	289,874.5	86,852.0	76.9
АРГА ХЭМЖЭЭ 81603- Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	217,649.0	195,531.9	22,117.1	89.8
АРГА ХЭМЖЭЭ 83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан нэмэлт санхүүжилт	152,723.4	109,584.1	43,139.3	71.7

Эх сурвалж:2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан,

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар 327,086.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны ЭМД-гийн сангаас авах авлагын гүйлгээ байна. Нэмэлт санхүүжилтийн дансыг 2022 оны 3-р сарын 31-нээр дуусгавар болгон хаах болсонтой холбоотой зарцуулагдаагүй үлдэгдлийн 38,273.3 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийн данс руу хааж, батлагдсан төсвийг нэмэгдүүлж өгсөн байна .

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Д.Цэцэгмаа нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 32 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад анхны батлагдсан төсөвт зардлын 593,725.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,905.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 6,679.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 828,397.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас батлагдсан төсвөөс 153,236.8 мянган төгрөгийг хэмнэсэн ба төрийн хэмнэлтийн хуулийн заалтад хамаарах дараах зардлыг хэмнэсэн байна. Үүнээс :

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,128.5 мянган төгрөг
- Хангамж, бараа материалын зардлаас 33,853.3 мянган төгрөг
- Нормативт зардлаас 21,066.9 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тайлант онд тендер зарлаагүй ба дулаанаар хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, хүнсний материал худалдан авах 4 гэрээний 217,733.7 мянган, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн 1,204,160.6 мянган төгрөгийн 30 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 329,083.3 мянган төгрөгийн 33 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 298,825.1 мянган төгрөгийн 12 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба аудитаар зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх заалт бүхий 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаж байгаа тухай тайланг 2022.05.02-ны 32 тоот албан бичгээр ирүүлж, Fas системд байршуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0,00	1	0,00	100
Нийт дүн	1	0,00	1	0,00	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн үлдэгдэл жил бүр нэмэгдэж байгаа тул төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа болон бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй нийлүүлэгдэж байгаа эмийн хугацаа, ашиглалт дээр анхаарч дүн шинжилгээ хийж төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах, төсвийн хөрөнгөөр авч буй үндсэн хөрөнгийн худалдан авах ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, түүний чанар, ашиглалтын байдалд Эрүүл мэндийн салбарын хэмжээгээр давтан аудит хийхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

5.Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил, дутагдал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---